

# СОЁМБО МЭДЭЭ

ТУСГАЙ  
ДУГААР

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.03.19 №12 (12)

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалах их сургууль хамтран “Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгэн зууны түүхэн хөгжил: 1921-2021 он” сэдэвт эрдэм шинжилгээний онол, арга зүйн хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын хэлсэн үг, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзоригийн үндсэн илтгэлийг бүрэн эхээр нь хүргэж байна.

## МОНГОЛ ЦЭРГИЙН ТҮҮХ ДЭНДҮҮ АУГАА ХИЙГЭЭД БАЯЛАГ

Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.САЙХАНБАЯР



Улс Монголынхоо гал голомт, туурга тусгаар байдлыг бат найдвартайгаар батлан хамгаалж, түүхэн сорилт, шалгуур бүрийг ялгуусан туг, ялалтын уухайгаараа мөнхөлж, баатарлаг тэмцэл, бадрангүй үйлсээрээ дархалсан Монгол Улсын Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын дайчин цогтой халуун мэндийг Монголынхоо нийт ард түмэн, иргэд залуучууд, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинтэй ажил, амьдралаа холбосон үе үеийн эх орончид, алба хаагчид, зорилго нэгт хамтран зүтгэгчид Та бүхэндээ өргөн дэвшүүлж.

Монгол цэргийн түүх дэндүү аугаа хийгээд баялаг. “Монголын түүх бол монгол цэргийн түүх юм” гэсэн үзэл санааг олон эрдэмтэн судлаачид дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсан түүх, түүний хөгжил, төлөвшил ч өнөөгийн Монгол орны эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хөгжил, цэцэглэлттэй салшгүй холбоотой, харилцан шүтэлцээтэй явж ирснийг бид мэднэ.

Эх орон, эрх чөлөө, тусгаар тогтнол бидэнд төрөөс заяагдмал бус монгол эхийн ариун хэвлийд бүрэлдэж, монгол нутгийнхаа алтан хөрсөнд шингэсэн үе үеийн баатарлаг эрс, халуун эх орончдын халих амь, урсах цус, асгарах хөлсний дусал бүрээр хэмжигдэх үнэ цэнтэй түүхэн ой тохиож буй энэ цаг мөчид залуу хойч үедээ ойлгуулж, нандинган эрхэмлэж явах учиртайг ухааруулахад энэхүү түүхтэй ой, тэмдэглэлт арга хэмжээний зорилго, утга учир оршиж байгаа юм.

Эдүгээ 74 дэх жилдээ албан ёсоор тэмдэглэж байгаа Зэвсэгт

хүчний ойн баяр бол Монголын ард түмний хувьд томоохон тэмдэглэлт баяруудын нэг, цэрэг эрсээ хүндэтгэж, тэднийг байгуулсан гавьяа, үйл хэргээр бахархаж ирсэн уламжлалын гүн бат илэрхийлэл юм.

Өвөг дээдсийнхээ баатарлаг, дайчин замналын залгамж халаа болсон өнөөгийн Монгол Улсын Зэвсэгт хүчин эх орноо Батлан хамгаалах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ, хуулийн хүрээнд даян дэлхийн энхийн үйлс болон эх орныхоо бүтээн байгуулалтын тэргүүн эгнээнд манлайлан оролцож, монгол цэргийн буурал түүхийг алдар гавьяаны алтан хуудсаар улам бүр баяжуулсаар байгаа салбарын сайдын хувьд туйлын сэтгэл хангалуун байна.

Миний бие Батлан хамгаалахын сайдын өндөр, хариуцлагатай албанд томилогдон

ажиллах хугацаандаа салбарынхаа хөгжлийг улам урагшлуулах чин хүсэл, эрмэлзлэлээ бодит ажил хэрэг болгохын төлөө төрийн хууль, бүрэн эрхийнхээ хүрээнд хичээнгүйлэн ажиллаж, шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсээр байгаагаа уламжлахад таатай байна. Тухайлбал, Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангах, улс орны бүтээн байгуулалтад зохион байгуулалттайгаар оролцон хувь нэмрээ оруулах, Зэвсэгт хүчний хөгжлийн санг арвижуулах шинэ эх үүсвэрийг бий болгох, тодорхой хөрөнгийг төвлөрүүлэх замаар Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад буй зэвсэглэл, техникийн шинэчлэлийн үйл ажиллагааг эхлүүлэх, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавч,

цэргийн сургалт, бэлтгэлийн түвшнийг бодитойгоор дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулж, ажиллаж, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх, цар тахлын халдвараас бие бүрэлдэхүүнийг урьдчилан сэргийлэх, халдвараар өвчилсөн иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалахад идэвхтэй оролцох зэрэг олон үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Батлан хамгаалах яамнаас дэвшүүлж байгаа бодлого, зорилтын хүрээнд амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Амжилт, бүтээл бүрийн ард үүрэг, зорилгоо ухамсарласан эгэл жирийн байлдагчаас эхлээд шат, шатны захирагч, дарга нар, Батлан хамгаалах салбарын нийт бие бүрэлдэхүүний сэтгэл, хүч хөдөлмөр, хичээл зүтгэл шингэсэн байдаг нь бахархалтай. Ухамсарт үйл хэргээ салбарынхаа хөгжил, дэвшлийн төлөө зориулан буй эрхэм Та бүхэндээ чин сэтгэлийн талархал дэвшүүлж, өрнүүн амжилтыг хүсэн өрөөе!

Эргэх орчлонгийн юмс үзэгдэл бүхэн өөрийн гэсэн цаг хугацаатай. Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхэн ой тохиож буй цаг дор бид хамтдаа эх орноо батлан хамгаалах үйлсэд зорилго, сэтгэл нэгдэн алба хааж байна. Бидний алба хааж буй энэ цаг хугацаа, түүхэн торгон мөч дахиж давтагдахгүй билээ. Тиймээс хүн бүр өөрийн хариуцсан ажил, албан тушаалдаа эзэн нь байж, хийсэн бүтээлтэй, хэлэх үгтэй, ирээдүй хойч үеийнхээ өмнө гишгэсэн мөртэй, гэгээн үйлстэй байх нь Та бидний эрхмээс эрхэм чухал үүрэг юм.

Ахмад үеийнхнийхээ бий болгосон гүн бат хөгжлийн суурин дээр Зэвсэгт хүчнээ шинэ цагийн хөгжил

дэвшилтэй нийцүүлэн хөгжүүлэх 2 дахь зуун руу хамтдаа хөл тавин алхан орж байна. Хөгжил, шинэчлэлийг гүнзгийрүүлэх асуудалд салбарын бодлого, төлөвлөлт нэн чухал нь мэдээж. Үүнээс дутахгүй хүчтэй нэг гол асуудал бол бие хүний хөгжлийн буюу хүний хүчин зүйлтэй холбоотой асуудлууд юм. Эх орноо батлан хамгаалах гэдэг ойлголт өнөө цагт олон шинэлэг ойлголт, ухагдахуун, үзэл хандлагын дунд оршиж байгааг Та бүхэн анзаарч байгаа биз ээ. Тиймээс мэдээллийн эрин зуунд бид хөл нийлэн алхаж өөрийгөө бүрэн танин мэдэх, өөрийгөө тал бүрээр хөгжүүлэх, өөрийнхөө нэрийг хичээж, үргэлж сайнаар гаргахыг эрмэлзэхээс Зэвсэгт хүчний шинэ зууны хөгжил эхлэх юм. Эх орноо батлан хамгаалах үйл хэрэг салбарынхаа нэр хүндийг хамгаалахаас, өөрийнхөө нэр төрийг цэвэр, ариун байлгах асуудал эхлэн гэж товчхондоо ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл Зэвсэгт хүчин маань нэр хүндтэй, хүчтэй, хөгжил дэвшилтэй байж гэмээ нь сая улс орноо найдвартай батлан хамгаалах үндэс, суурь баттай тавигдаж бид хамтын хүчээр Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнээ хөгжүүлж чадна.

Эх орноо батлан хамгаалагч дайчин Танд “Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, цаашдын ажил, албанд тэвчрэн, цаашдын ажил, албанд тэвчрэн ариун амжилт, амьдралд тань эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе.

ДОГШИН ИХ ХАР СУЛДНИЙ ЗАЯА ХИЙМОРЬ, ХӨХ МОНГОЛ ЦЭРГЭЭЙ МӨНХӨД СОЁРХОХ БОЛТУГАЙ!

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
-5°C	-17°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
37°C	26°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
18°C	7°C

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,388.0	3,456.0
CNY	437.10	441.40
RUB	37.96	39.72
JPY	25.89	26.42
KRW	2.48	2.60

КОВИД-19 МЭДЭЭ	
ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	160
НИЙТ БҮРТГЭГДСЭН	4658
ЭДГЭРСЭН	3296
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	
ШИНЭЭР НЭМЭГДСЭН	11
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	248
ЭДГЭРСЭН	959

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.19  
/БААСАН ГАРАГ/  
ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ХОЁР ХАР УЛААН БАР ӨДӨР

Үс засуулвал:  
Өнгө зүс сайжирна  
Наран ургах, шингэх:  
06.57-19.03

Барилдлага: Шид Шүтэн барилдлага:  
Хурьцахуй  
Суудал: Мод

Аргын тооллын 3 сарын 19, Сугар гараг, Билгийн тооллын 6, Чөлөөт эх одтой, улаан бар өдөр. Өдрийн наран 6 цаг 57 минутад мандан, 19 цаг 03 минутад жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн туллаг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлзлэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.

## МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГЭН ЗУУНЫ ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ЗАМНАЛ, ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.ГАНЗОРИГ

Монгол түмэн Манж чин гүрний эрхшээл дор 200 гаруй жил дарлагдаж төр улсынхаа тусгаар тогтнол, ард олныхоо эрх чөлөөт байдлыг алдаж, хэдэн үеэрээ үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн тогтоохын төлөө тэмцэж ирсэн юм.

XIX зууны эцэс, XX зууны эхнээс дэлхий дахинаа өрнөсөн хувьсгалт үйл явдлын нөлөөгөөр Ази тивд олон түүхт үйл явдал өрнөсний нэг хэсэг нь Манж чин гүрний дарлалыг эсэргүүцсэн хятад дахь бослого байлаа. Хятадад 300 шахам жил (1616-1912) тогтносон Манж чин улсын ноёрхол нуран унах үед монгол дахь эрх чөлөөний хөдөлгөөн эрч хүчтэй өрнөсөн юм. Энэ үед Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Чин улсын захиргаанд байгаа бүх нутгаа чөлөөлж, Их хүрээнд монголчууд засгийн эрхийг авсан ба баруун хязгаараас Манжийн сайд түшмэдийг цэрэг, зэвсгийн хүчээр хөөн зайлуулсан юм.

Богд хаант Монгол Улсыг байгуулж, үндэсний ашиг сонирхлыг дээдэлж, Хаант Орос Улсын Монгол дахь улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг харгалзан, "... Өөрийн цэрэг байгуулах эрхийг алдагдуулахгүй сахихад цөм тусална" гэсэн гэрээ хэлэлцээр байгуулан цэрэг, зэвсгийн тусламж авч байв. Гэвч 1919 оны намар Хятадын засгийн газраас Сю Шүжанаар удирдуулсан цэргийн хүчээр Нийслэл хүрээг эзлүүлэн цэргийн дэг журмыг Монголд тогтоосон.

Харин 1921 оны Ардын хувьсгалаар Монгол Улс тусгаар тогтнолоо олж, ард түмэн нь эрх, эрх чөлөөгөө эдлэх үүд хаалгыг нээсэн юм. Ардын хувьсгалын ялалт нь Монголын Зэвсэгт хүчинтэй салшгүй холбоотой бөгөөд Монголын ард түмний өмнө байгуулсан гавьяат үйлсээрээ түүхэнд мөнхлөгджээ. Манай Зэвсэгт хүчин нэгэн зууны алдар гавьяат түүхэн замналыг туулсан түүхтэй.

Морин дэл дээр тэмцэл өрнүүлж, төрт улсаа байгуулах, моринхоосоо буугаад улс орноо төвхнүүлэх үйл хэрэгт Монгол Ардын Журамт цэргээс эхтэй Зэвсэгт хүчин маань чин үнэнээр зүтгэж, ард түмнийхээ амар амгаланг бүрдүүлж иржээ.

Монгол Улсын өнөөгийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард түмний маань эрх чөлөөт амьдрал, өнөөгийн ардчилал, монгол хүний эрхийг хангахын төлөөх үйлс, ирээдүйн гэгээлэг үйл хэргийн төлөөх хүсэл



мөрөөдөл Монголын Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбоотой, түүний хүлээх хариуцлага өндөр байна.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛДАРТ ТҮҮХЭН ЗАМНАЛ, СУРГАМЖ, ГАВЬЯА, БАХАРХАЛ, АЛДАР ХҮНДЭТГЭЛ

Монгол Ардын Журамт цэрэг Жанжин Д.Сүхбаатарын удирдлагын дор үүсгэн байгуулагдаж, төр улсаа дахин байгуулах, эзэн богд Чингис хааныхаа байгуулсан Их Монгол Улсынхаа гал голомтыг сэргээн бадраасан нь саяхан мэт боловч нэгэн зууныг өнгөрөөжээ. Тусгаар тогтносон Монгол Улсаа байгуулахын төлөө

халуун амь, бүлээн цусаа асгаруулсан МАЖЦ-ийн партизануудын алдар гавьяа мөнхөд дурсагдаж, тэдэнд гүнээ хүндэтгэл үзүүлж байх нь монголчуудын эрхэмлэх үйлсийн нэг мөн.

Тухайн цаг үеийн Монгол Ардын Намын удирдлага, МАЖЦ-ийг үүсгэн байгуулагчдын улс төрийн бодлого, улсынхаа тусгаар тогтнолыг олж авахын төлөөх стратегийн зорилт, түүнийгээ хэрэгжүүлсэн хичээл зүтгэл нь Монголын түүхэнд мөнхлөгдсөн, үнэхээр гавьяат үйл явдал мөн. Энэ нь эр зориг байхад, улс төрийн том бодлого боловсруулан стратегийн зорилгоо тодорхойлж, түүнийгээ биелүүлэх, хэрэгжүүлэх арга хэрэгсэл, тактикаа ухаалгаар явуулбаас "хүрэхгүй, чадахгүй зүйл гэж үгүй болохыг өнөөдрийн бидэнд сургамжилж байна.

МАЖЦ-ийн Шивээ Хиагтыг эзлэн авсан, Тужийн нарсанд цусаа асгаруулсан, Хятадын Гоминдан цэрэг, Оросын цагаантантай тэмцэл явуулсан бүхэн монгол түмний ой санамжид хадгалагдахгүй аваас өнөө үеийн мэдээллийн дайнд ялагдал хүлээх нэгэн шалтгаан болно. Монголын хойч үе хүүхэд, залуучуудад Монгол Улсынхаа тусгаар тогтнол, эх орноо хамгаалах ухамсар, сэтгэл, зүтгэл

дундуур болбоос даяаршлын эрин зуунд дангааршиж чадахгүйд хүрч, бүрэн эрхт байдлаа алдах эрсдэлтэй юм.

Эх орноороо, унаган байгалийнхаа үзэсгэлэнгээр, байгалийн баялгаар, монгол хүнийхээ эр зориг, эрдэм ухаан, бүтээх, туурвих чадвар, авьяас билэг, алдар цуугаар бахархаж байх нь монгол үндэстэн оршин байхын үндэс байх болно. Үндэсний үзэл хүмүүжил бол бага үндэстэнд тусгаар тогтнолоо хамгаалж байхын эх сурвалж болохыг манай эрдэмтэн мэргэд сургаал болгож үлдээсэн нь ийм учиртай ажээ.

(Үргэлжлэл нь II нүүрт)

